

БНСУ-ын Соул хотноо 2014 оны 12 дугаар сарын 01-05-ний өдрүүдэд БНСУ-ын Батлан хамгаалахын дүн шинжилгээний хүрээлэн, Монгол Улсын Батлан Хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн хамтарсан эрдэм шинжилгээний хуралд БХЭШХ-ийн дэд захирал, эрдэмтэн нарийн бичгийн дарга, хурандаа Ц.Дэмчигсүрэн, Дайн, цэргийн урлаг судлалын товийн эрдэм шинжилгээний ажилтан Ц.Дашзэвэг, Аюулгүй байдал, батлан хамгаалах бодлого судлалын товийн эрдэм шинжилгээний ажилтан ахлах дэслэгч Т.Сүхбаатар, БХИС-ийн захирлын туслах, хуулийн зовлох дэслэгч Д.Монх-Онор нар оролцлоо.

12 сарын 2 ны одор KIDA буюу БНСУ-ын Батлан хамгаалахын дүн шинжилгээний хүрээлэнгийн тов байраар зочлон, тус хүрээлэнгийн музейг үзэж танилцсанаар хурлын вйл ажиллагаа эхлэсэн.

Хурал үндсэн 3 хэсгээс бүрдэж байлаа. Хурлын нэгдүгээр вед Монгол Улсын талаас дэслэгч Д.Монх-Онор “Зүүн хойд Азийн аюулгүй байдал ба Монгол Улсын санаачлага”, БНСУ-ын талаас Ин Хю Соул “Солонгосын хойг дахь АНУ-ын байр суурь”, хоёрдугаар вед Монгол Улсын талаас эрдэм шинжилгээний ажилтан Ц.Дашзэвэг “Солонгосын хойгийн хямрал ба Монгол Улсын үүрэг оролцоо”, БНСУ-ын талаас Кёнхи их сургуулийн багш доктор профессор Ким Хён “Солонгосын хойгт энх тайван тогтооход хорш орнуудын үүрэг оролцоо”, хурлын гуравдугаар хэсэгт Монгол Улсын талаас эрдэм шинжилгээний ажилтан ахлах дэслэгч Т.Сүхбаатар “Зүүн хойд Азийн аюулгүй байдлын орчин”, БНСУ-ын талаас Вүү Хён Вок “БНСУ-Монгол Улсын Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хамтын ажиллагаа, ирээдүйн явцын үнэлгээ” сэдвээр тус илтгэл тавьж хэлэлцүүлэв.